



# Монголын Татварын Алба

Маягт ТТ-03а

## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР СУУТГАН ТӨЛӨГЧИЙН ТАЙЛАН

Татварын жил: |\_|\_|\_|\_|

/он/

Тайлант хугацаа: |\_|\_|\_|\_| –ээс |\_|\_|\_|\_|-ыг дуустал  
сар, өдөр сар, өдөр

### Татвар төлөгчийн мэдээлэл:

ТТ-ийн дугаар:	_ _ _ _ _ _ _ _ _	Утас:	_ _ _ _ _ _ _ _ _
ТТ-ийн нэр:	_____	Факс:	_ _ _ _ _ _ _ _ _
Аймаг, хот:	_____	Шуудангийн хайрцаг:	_____
Сум, дүүрэг:	_____	И-мэйл хаяг:	_____
Баг, хороо:	_____	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл:	_____
Хороолол:	_____	Салбарын ангиллын код:	_____
Гудамж, байшин:	_ _ _ _	Толгой компанийн регистрийн дугаар:	_ _ _ _ _ _ _
Хашаа, тоот:	_ _ _ _		

### Татварын албаны мэдээлэл:

Татварын төрлийн код:	_ _ _ _ _ _ _	Татварын албаны код:	_____
Тайлангийн үечлэл:	_____	Тайлант үе:	_____
Татварын байцаагч:	_____	Хүлээн авсан огноо:	_____

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол |√| энд тэмдэглэнэ үү.

(төгрөгөөр)

### А. ТУХАЙН САРЫН БОРЛУУЛСАН БАРАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО

Тухайн сарын нийт борлуулалтын орлого		1(2+3)	
Хуулийн 13 дугаар зүйлд заасан тухайн сарын НӨАТ-аас чөлөөлөгдөх борлуулалт /хавсралтаас өөрт хамаарах чөлөөлөгдөх борлуулалтын орлогыг сонгоно /		2	
Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээний нийт борлуулалтын орлого		3(4+10+30)	
<b>НӨАТ ногдох бараа борлуулсны орлого</b>		4(5+...+9)	
Үүнээс	Дотоодын зах зээлд борлуулсан барааны борлуулалтын орлого	5	
	Бусад барааны борлуулалтын орлого	6	
	Эрх борлуулсны орлого	7	
	Татан буугдах үед өөрт үлдээсэн барааны орлого	8	
	Өрийн төлбөрт шилжүүлсэн барааны орлого	9	
<b>НӨАТ ногдох ажил, үйлчилгээний орлого</b>		10(11+...+24)	
Үүнээс	Өрийн төлбөрт тооцсон ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлсний орлого	11	
	Цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, шуудан, харилцаа холбооны болон бусад үйлчилгээ үзүүлсний орлого	12	
	Бараа түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах үйлчилгээний орлого	13	
	Зочид буудал буюу түүнтэй адилтгах байранд байр түрээслүүлэх, бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах үйлчилгээний орлого	14	

	Үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх ашиглуулах үйлчилгээний орлого	15	
	Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхэд хамаарах бүтээл, барааны тэмдэг, ноу-хау, хөрөнгийн мэдээллийг шилжүүлсэн, түрээсэлсэн, худалдсаны орлого	16	
	Эд мөнгөний хонжворт сугалаа, төлбөрт таавар бооцоот тоглоомын үйл ажиллагааны орлого	17	
	Зуучлалын үйлчилгээний орлого	18	
	Бусдын буруутай үйл ажиллагааны улмаас авсан хүү, торгууль, алдангийн орлого	19	
	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний орлого	20	
	Төрөөс олгож буй төсвийн санхүүжилт, татаас, урамшууллын орлого	21	
	Өмгөөлөл, хууль зүйн зөвлөлгөө өгөх үйлчилгээний орлого	22	
	Үсчин, гоо сайхан, засвар үйлчилгээ, угаалга, хими цэвэрлэгээний үйлчилгээний орлого	23	
	Хуулийн 13 дугаар зүйлд зааснаас бусад бүх төрлийн үйлчилгээний орлого	24	
	<b>Тухайн сарын НӨАТ ногдох дотоодын бараа, ажил, үйлчилгээний орлого</b>	<b>25(4+10)</b>	
	<b>Ногдуулсан татвар</b>	<b>26(25*10%)</b>	
	Нэмэгдсэн өртгийн албан татварын 0 хувь хэрэглэх бараа борлуулсны орлого	27	
	Нэмэгдсэн өртгийн албан татварын 0 хувь хэрэглэх үйлчилгээ үзүүлсний орлого	28	
	<b>Тухайн сарын НӨАТ ногдох экспортын бараа, ажил, үйлчилгээний орлого</b>	<b>29(27+28)</b>	
	<b>Ногдуулсан татвар</b>	<b>30(29*0%)</b>	
	<b>Тухайн сард ногдуулсан НӨАТ-ын нийт татвар</b>	<b>31(26+30)</b>	

**Б. ТУХАЙН САРД ХУДАЛДАН АВСАН БАРАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО**

	<b>Тухайн сард худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нийт дүн</b>	<b>32</b>	
	Тухайн сард худалдан авсан БАҮ-нээс НӨАТ-тай худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний дүн	33(34+...+38)	
Үүнээс	Импортын бараа, ажил үйлчилгээний дүн ( НӨАТ-гүй дүн)	34	
	Дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн дүн ( НӨАТ-гүй дүн)	35	
	Суутган төлөгчөөр бүртгүүлэх үед импортоор оруулсан болон бусдаас худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний дүн /НӨАТ-гүй дүн/	36	
	Тухайн жилд хамаарах барилга байгууламж, тоног төхөөрөмж /Үүнд хайгуулын үйл ажиллагааны зардал хамаарна/ бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон барилга байгууламж, тоног төхөөрөмж худалдан авах, импортлоход төлсөн дүн /НӨАТ-гүй дүн/	37	
	Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс худалдан авсан мах, сүү, өндөг, арьс шир, хонь тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөвөр, мах боловсруулах, үйлдвэрлэлд зориулан бэлтгэх, таван хошуу мал, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотоодод үйлдвэрлэсэн гурилыг худалдан авсан дүн / НӨАТ-гүй дүн/	38	
	• <b>Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ын нийт дүн</b>	<b>39(33*10%)</b>	
	• <b>Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн хасагдахгүй НӨАТ-ын дүн</b>	<b>40(41+...+45)</b>	
Үүнээс	Суудлын автомашин, түүний эд анги сэлбэгт төлсөн НӨАТ	41	
	Хувьдаа болон ажиллагсдын хэрэгцээнд зориулж худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ	42	
	Хуулийн 13 дугаар зүйлд заасан чөлөөлөгдөх үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж импортолсон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ	43	
	Ашиглалтын өмнөх үйл ажиллагаанд зориулж импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ	44	

Тайлант хугацааны албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээтэй хамааралгүй импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ	45	
• <b>Тухайн сард хасагдах НӨАТ-ын дүн</b>	46(39-40)	

**В. САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ЗҮЙЛИЙН БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ЗҮЙЛИЙН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО**

Санхүүгийн түрээсийн зүйлийг санхүүгийн түрээсээр дотоодын зах зээлд борлуулсны орлого	47	
Факторинг, форфайтинг зэрэг тэдгээртэй адилтгах хэлцлийн үйлчилгээний орлого	48	
<b>Ногдуулсан НӨАТ</b>	49(47+48)*1 0%	
Санхүүгийн түрээсийн зүйлийг санхүүгийн түрээсээр дотоодын зах зээлээс худалдан авахад төлсөн түрээсийн төлбөр /төлбөр хийхээр тохирсон хуваарийг баримтлан/	50	
Факторинг, форфайтинг зэрэг тэдгээртэй адилтгах хэлцлийг худалдан авахад төлсөн төлбөр /төлбөр хийхээр тохирсон хуваарийг баримтлан/	51	
<b>Хасагдах НӨАТ</b>	52=(50+51)* 10%	

**Г. ТУХАЙН САРЫН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦООЛОЛ**

<b>Тухайн сард төлбөл зохих НӨАТ</b>	53=(31+49)	
<b>Тухайн сард буцаан авах НӨАТ</b>	54=(46+52)	

**Д. ТАЙЛАНГИЙН ЗАЛРУУЛГА**

Борлуулалтын орлогын буцаалт, хөнгөлөлтийн дүн	55	
<b>Төлсөн НӨАТ</b>	56=(55*10% )	
Худалдан авалтын буцаалт, хөнгөлөлтийн дүн	57	
<b>Хасагдах НӨАТ</b>	58=(57*10% )	

**Е. ТУХАЙН САРЫН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦООЛОЛ**

<b>ҮҮНД:</b>	<b>НИЙТ ТӨЛБӨЛ ЗОХИХ НӨАТ</b>	59=(53+58)	
	<b>НИЙТ БУЦААН АВАХ НӨАТ</b>	60=(54+56)	
	<b>ЭЦСИЙН ТООЦООГООР ТӨЛБӨЛ ЗОХИХ НӨАТ</b>	61 +(59-60)	
	<b>ЭЦСИЙН ТООЦООГООР БУЦААН АВАХ НӨАТ</b>	62 -(59-60)	

**Тайланг үнэн зөв гаргасан:**

Захирал ..... /...../  
гарын үсэг нэр

Эрх бүхий этгээд ..... /...../  
гарын үсэг нэр

**Тайланг хүлээн авсан:**

Татварын улсын ..... /...../  
(ахлах) байцаагч: гарын үсэг нэр



---

Албан татвар суутган төлөгч нь тайланг дараа сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушаана.  
Тайлант хугацаанд оршин суугч бус этгээдээс суутгасан нэмэгдсэн өртгийн албан татварыг ТТ-03б маягтаар тайлагнахыг анхаарна уу!

## **Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн тайлангийн маягт /ТТ-03а/ нөхөх заавар**

Нэмэгдсэн өртгийн албан татвар цаашид /НӨАТ/ гэх суутган төлөгчийн тайланг сарын дүнгээр төгрөгөөр гарган сар бүр татварын албанд илгээнэ.

НӨАТ суутган төлөгчийн тайлан нь тухайн сарын борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо /А/, тухайн сарын худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо /Б/, санхүүгийн түрээсийн зүйлийн болон санхүүжилтын хэлэлцээрийн зүйлийн нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо /В/, тухайн сарын нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоолол /Г/, өмнөх сарын тайлангийн залруулга /Д/, тухайн сарын нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоолол /Е/, гэсэн 6 хэсгээс бүрдэнэ.

### **А. ТУХАЙН САРЫН БОРЛУУЛСАН БАРАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО**

- Тухайн сарын нийт борлуулалтын орлого /мөр 1/-д тавигдах дүн нь тухайн сарын НӨАТ-аас чөлөөлөгдөх борлуулалт /мөр 2/ дээр тухайн сарын дотоодын нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээний нийт борлуулалт /мөр 3/-ыг тус тус нэмж тодорхойлно.
- Тухайн сарын НӨАТ-аас чөлөөлөгдөх борлуулалт /мөр 2/-д тавигдах дүн нь НӨАТ-ын тухай хуулийн дагуу тодорхойлсон чөлөөлөгдөх орлогуудын нийлбэр дүн байх бөгөөд тайлан гаргагч өөрт хамаарах чөлөөлөгдөх орлогуудыг хавсралт мэдээ /ТТ-03а-1/-д сонгон оруулж, нийт дүнг тайлангийн маягтад хуулна. Дээрх дүн нь НӨАТ-ын тайлангийн хавсралт мэдээ /ТТ-03а-2-ын 5 дугаар мөр/-тэй тэнцүү байхыг анхаарна уу.
- Тухайн сарын НӨАТ ногдох бараа борлуулсны орлого /мөр 4/-д тавигдах дүн нь мөр 5-9 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- Тухайн сарын НӨАТ ногдох ажил, үйлчилгээ борлуулсны орлого /мөр 10/-д тавигдах дүн нь 11-24 дүгээр мөрүүдэд заагдсан орлогуудын нийлбэр дүн байна.
- Тухайн сарын дотоодын бараа, ажил, үйлчилгээний орлого /мөр 25/ нь тухайн сарын НӨАТ ногдох бараа борлуулсны орлого /мөр 4/ болон тухайн сарын НӨАТ ногдох ажил, үйлчилгээ борлуулсны орлого /мөр 10/-ын нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- Ногдуулсан татвар /мөр 26/-д тавигдах дүн нь 25 дугаар мөрийн дүнг 10 хувиар үржүүлж гарсантай тэнцүү байна.
- Тухайн сарын НӨАТ-ын 0 хувь хэрэглэх бараа борлуулж, ажил үйлчилгээ үзүүлсний орлогын дүн /мөр 29/-д хуулийн 12 дугаар зүйлд тодорхойлсон орлогууд хамаарна. Дээрх орлого нь нэмэгдсэн өртгийн албан татварын 0 хувь хэрэглэх бараа борлуулсны орлого /мөр 27/ дээр нэмэгдсэн өртгийн албан татварын 0 хувь хэрэглэх үйлчилгээ үзүүлсний орлого /мөр 28/-ын нийлбэр дүнгээр тодорхойлогдоно. Мөн дээрх орлогуудын дүн нь тайлангийн хавсралт мэдээ /ТТ-03а-2-ын 6 дугаар мөр/ -тэй тэнцүү байхыг анхаарна уу.
- Ногдуулсан татвар /мөр 30/-т тавигдах дүн нь мөр 29-ийн дүнг 0 хувиар үржүүлж гарсантай тэнцүү байна.

- Тухайн сард ногдуулсан нийт татвар /мөр 31/ нь дотоодын борлуулалтад ногдуулсан татвар /мөр 26/ дээр 0 хувь хэрэглэх бараа, ажил, үйлчилгээнд ногдох татвар /мөр 30/-ын нийлбэр байна.

## **Б. ТУХАЙН САРД ХУДАЛДАН АВСАН БАРАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО**

- Тухайн сард худалдан авсан бараа, ажил үйлчилгээ /БАҮ/-ний нийт дүн /мөр 32/-д тавигдах дүн нь монгол улсад импортолсон болон дотоодын зах зээлээс худалдан авсан нийт бараа, ажил үйлчилгээний нийлбэр дүн байна.
- Тухайн сард худалдан авсан БАҮ-нээс НӨАТ-тай худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний /мөр 33/ -д тавигдах дүн нь импортын бараа, ажил, үйлчилгээ /мөр 34/, НӨАТ-тай үнээр дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ /мөр 35/, суутган төлөгчөөр бүртгүүлэх үед НӨАТ-тай үнээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ /мөр 36/, Тухайн жилд хамаарах барилга байгууламж, тоног төхөөрөмж /Үүнд хайгуулын үйл ажиллагааны зардал хамаарна/ бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон барилга байгууламж, тоног төхөөрөмж худалдан авах, импортлоход төлсөн дүн /НӨАТ-гүй дүн/ /Мөр 37/, Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс худалдан авсан мах, сүү, өндөг, арьс шир, хонь тэмээний ноос, ноолуур, сарлагийн хөөвөр, мах боловсруулах, үйлдвэрлэлд зориулан бэлтгэх, таван хошуу мал, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотоодод үйлдвэрлэсэн гурилыг худалдан авсан дүн /мөр 38/-г нэмж тодорхойлсон дүн байна. Тайлан сард ногдох барилга байгууламж, тоног бэлтгэхэд бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн болон барилга байгууламж худалдан авахад төлсөн НӨАТ /мөр 37/-д зөвхөн тайлант сард хамаарах буюу НӨАТ-ын тайлангийн ТТ-03а маягтын хавсралт мэдээ /ТТ-03а-8/-ны 13 дугаар мөрийн нийт дүнг маягтад оруулна. Дуусаагүй барилгыг тухайн барилга ашиглалтад орох, хайгуулын үйл ажиллагааны зардлыг ашиглалтын тусгай зөвшөөрөл гарах үед НӨАТ-аас хасах эрх үүсэх бөгөөд хэрэгжих хүртэл хасагдах НӨАТ-ыг ЦТБС-д хуримтлуулж явна.
- Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ын нийт дүн /мөр 39/-д тавигдах дүн нь 33 дугаар мөрийн дүнг 10 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.
- Тухайн сард худалдан авсан суудлын автомашин, түүний эд анги сэлбэгт төлсөн НӨАТ /мөр 41/-ын дүнг тус мөрөнд тусгана. Харин суудлын автомашин, түүний эд анги сэлбэг хэрэгслийг худалдан борлуулах үйл ажиллагааг эрхлэн явуулахаар өөрийн гэрээ, дүрэмд тусган түүний дагуу үйл ажиллагаа явуулж татвар төлөгч хамаарахгүй.
- Тухайн сард хувьдаа болон ажиллагсдын хэрэгцээнд зориулж худалдан авсан бараа, ажил, үйлчил төлсөн хасагдахгүй НӨАТ /мөр 42/-ын дүнг тус мөрөн тайлагнана.
- Тухайн сард худалдан авсан хуулийн 13 дугаар зүйлд заасан чөлөөлөгдөх үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж импортолсон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ыг /мөр 43/-нд тайлагнана. Харин нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т заасан гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн

тусламж, хөнгөлөлттэй зээлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчид бараа борлуулж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлсэн бол дээрх заалт хамаарахгүй.

- Ашиглалтын өмнөх үйл ажиллагаанд зориулж импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ /мөр 44/-ын нийлбэр дүнг тус мөрөнд тусгана.
- Тухайн сард албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээтэй хамааралгүй импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-ын нийлбэр дүнг /мөр 45/-д тайлагнана.
- Тухайн сард худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн хасагдахгүй НӨАТ /мөр 46/-ын дүн нь НӨАТ-ын тайлангийн маягтын Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн хасагдахгүй НӨАТ-ын дүн (41+42+43+44+45) дүнтэй тэнцүү байна.

## **В. САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ЗҮЙЛИЙН БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ЗҮЙЛИЙН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО:**

- Санхүүгийн түрээсийн зүйлийг санхүүгийн түрээсээр дотоодын зах зээлд борлуулсны орлого /мөр 47/-д тавигдах дүн нь санхүүгийн түрээсийн зүйлийг түрээслүүлж байгаа НӨАТ суутган төлөгчид хамаарна.
- Факторинг, форфайтинг зэрэг тэдгээртэй адилтгах хэлцлийн үйлчилгээний орлогыг /мөр 48/-д тавина.
- Ногдуулсан НӨАТ /мөр 49/-д тавигдах дүн нь 47, 48 дугаар мөрийн нийлбэр дүнг 10 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.
- Санхүүгийн түрээсийн зүйлийг санхүүгийн түрээсээр дотоодын зах зээлээс худалдан авахад төлсөн түрээсийн төлбөр /мөр 50/ -д тавигдах дүн нь санхүүгийн түрээсийн зүйлийг түрээслэн авч байгаа НӨАТ төлөгчид хамаарна.
- Факторинг, форфайтинг зэрэг тэдгээртэй адилтгах хэлцлийг худалдан авахад төлсөн төлбөрийг төлбөр хийсэн хуваарийг баримтлан /мөр 51/-д тавина.
- Хасагдах НӨАТ /мөр 52/-д тавигдах дүн нь 51, 52 дугаар мөрийн нийлбэр дүнг 10 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.

## **Г. ТУХАЙН САРЫН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦОО:**

- Тухайн сард төлбөл зохих НӨАТ /мөр 53/ нь тухайн сард ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татвар /мөр 31/ дээр санхүүгийн түрээсийн зүйлийн болон санхүүжилтийн хэлэлцээрийн зүйлийн НӨАТ-ын тооцоо /мөр 49/-ийг нэмсэн дүн байна.
- Тухайн сард буцаан авах НӨАТ /мөр 54/ нь тухайн сард хасагдах нэмэгдсэн өртгийн албан татвар /мөр 46/ дээр санхүүгийн түрээсийн зүйлийн болон санхүүжилтийн хэлэлцээрийн зүйлийн хасагдах НӨАТ-ын тооцоо /мөр 52/-ийг нэмсэн дүн байна.

## **Д. ӨМНӨХ САРЫН ТАЙЛАНГИЙН ЗАЛРУУЛГА:**

- Өмнөх сарын борлуулалтын орлогын буцаалт, хөнгөлөлтийн залруулгын дүнг 55 дугаар мөрөнд тусгана.
- Төлсөн НӨАТ буюу буцаан авах НӨАТ /мөр 56/-д тавигдах дүн нь 55 дугаар мөрийн дүнг 10 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.
- Өмнөх сарын худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний буцаалт, хөнгөлөлтийн залруулгын дүнг 57 дугаар мөрөнд тусгана.
- Тухайн сарын худалдан авалтаас хасагдах НӨАТ /мөр 58/-д тавигдах дүн нь 57 дугаар мөрийн дүнг 10 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.

#### **Е. ТУХАЙН САРЫН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦООЛОЛ:**

- Тухайн сарын нийт төлбөл зохих НӨАТ /мөр 59/ нь тухайн сард төлбөл зохих НӨАТ / мөр 53/ дээр өмнөх сарын худалдан авалтын буцаалт, хөнгөлөлтийн хасагдах НӨАТ-ын дүн /мөр 58/-г нэмсэн дүн байна.
- Тухайн сарын нийт буцаан авах НӨАТ /мөр 60/ нь тухайн сард буцаан авах НӨАТ-аас /мөр 54/ дээр өмнөх сард тайлагнасан борлуулалтын орлогын буцаалт, хөнгөлөлтийн дүн /мөр 56/-г нэмсэн дүн байна.
- Эцсийн тооцоогоор төлбөл зохих НӨАТ нь 59 дүгээр мөрний дүнгээс 60 дугаар мөрийн дүнг хасаад ялгавар нь эерэг гарвал 61 дугаар мөрөнд, сөрөг тэмдэгтэй гарвал 62 дугаар мөрөнд тавигдана.
- Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч нь энэхүү тайлангийн маягтаар 2019 оны 01 дүгээр сараас эхлэн тайлагнана.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР